



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 18 өдөр

Дугаар 266

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус үндэслэн “Төв АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 197,600,000.00 (нэг зуун ерэн долоон сая зургаан зуун мянган) төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны А-1/66 дугаартай албан даалгаврын биелэлтээр 88.7 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байх тул албан даалгаврын биелэлтийг ханган ажиллахыг “Төв АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Болдбаатарт үүрэг болгосугай.

2.“Төв АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3.“Төв АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөсүгэй:

3.1.Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах;

3.2.Компанийн батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үндэслэн тайлант жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах, гүйцэтгэлд нь хяналт тавих.

4.“Төв АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Болдбаатарт дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

4.1 Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

4.2.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээгээр олгосон эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулах, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөгөөр баталсан зардлаас бусад зардлыг санхүүжүүлэхгүй байх;

4.3.“Ялгуусан” ХХК-тай байгуулсан гэрээт ажлын санхүүжилт 312.9 сая (гурван зуун арван хоёр сая есөн зуун мянган) төгрөгийн авлагыг шуурхай барагдуулах, арга хэмжээ авч ажиллах;

4.4.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны

журам"-ыг мөрдлөг болгон ажиллах, зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, төрийн өөрийн өмчит бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;

4.5.Компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Дундговь аймаг, Өмнөговь аймагт байршилтай үл хөдлөх хөрөнгүүдийн түрээсийн сонгон шалгаруулалтыг 2022 оны 3 дугаар улиралд багтаан журмын дагуу зохион байгуулах, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах;

4.6.Компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, сэргээн засварлах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй болсон 6.4 сая (зургаан сая дөрвөн зуун мянган) төгрөгийн үлдэгдэл үнэ бүхий, ТӨВ-45-92 улсын дугаартай, авто краныг акталж сэлбэгээр ашиглах асуудлыг Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

4.7.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээслүүлснээс олсон орлогоос Улсын төсөвт төвлөрүүлэх хувь хэмжээ тогтоох тухай" 49 дүгээр тогтоолын дагуу 2021 онд төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлснээс олсон орлогын 40 хувь, 2.3 сая (хоёр сая гурван зуун мянган) төгрөгийг 2 дугаар улиралд багтаан Улсын төсөвт нөхөн төвлөрүүлэх;

4.8.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй бараа, ажил, үйлчилгээ худалдан авахгүй байх, үйл ажиллагаандаа "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль", Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан "Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ыг мөрдөн ажиллах;

4.9.Тогтоолын биелэлтийг 2022 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

5.Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх чиглэлээр анхаарч ажиллах.

6.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасгай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн
13/6 дугаар тогтоолын хавсралт

“Төв АЗЗА” төрийн өмчит компанид хийсэн
шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах
арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил дутагдлын утга	Мөнгөн дүн /сая төгрөгөөр/	Зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт
1	2021 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй зардлыг санхүүжүүлсэн.	113.7	Батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөг мөрдөн ажиллах.
2	Худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авалт хийсэн.	81.6	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг болон Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах.
3	Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө бусдад түрээслүүлэн, олсон орлогоос Улсын төсөвт төвлөрүүлээгүй.	2.3	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах.
Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын дүн:		197.6	(Нэг зуун ерэн долоон сая зургаан зуун мянга)

-----oO-----